

НУР АД-ДИНИЙ САНГИЙН 1272 ОНЫ ГЭРЭЭ БИЧГИЙН

АРАБ ЭХИЙН МОНГОЛ ОРЧУУЛГЫН ТУХАЙ

/Кыршехирийн I гар бичмэлийн жишээн дээр/

Б.Арьяажав* (МУИС)

Манай судлаач, уншигчид Монголын дундад үеийн түүхнээ холбогдох араб хэлээрх сурвалжийг ашиглахдаа арабаас орос, англи зэрэг хэлнээ орчуулсан зүйлийг дам хэрэглэж буй ба энэ нь эртний сурвалжийг тухайн хэлнээс эх хэл рүүгээ шууд орчуулан эрдэм шинжилгээ эрхлэгч, эх түүхээ сонирхон уншигч нарын эгээрэл хүсэлд нийцсэн орчуулгыг үйлдэх эрхэм шаардлагыг нөхцөлдүүлж байна.

Үүнийг өгүүлэгч 2005 онд монгол араб хэлээр бичсэн эл сурвалжийн араб эхийг монгол эхтэй харьцуулан судалж орчуулсан ба араб эхийн сийрүүлэг, монгол орчуулгыг 2011 онд нийтлүүлсэн. Энэ удаа уг сурвалжийн араб эхийг орчин цагийн утга зохиолын монгол хэлнээ хэрхэн буулгаснаа өгүүлье.

Юуны өмнө энэ сурвалжийг хэрхэн орчуулсан тухайгаа цөөн жишээгээр товч төдий танилцуулья.

Сонгодог бичгийн өмнөх үеийн монгол бичгийн дурсгал бага Азиас цөөн олдсоны нэг нь бидний судалж буй, Нур ад-Диний сангийн гэрээ бичиг болно. Нур ад-Дин Жэбра'йл нь Ил хаант улсын Абага хааны үе (1265-1282)-д Анатолийн хойгийн Кыршехир хотын захирагч байсан бөгөөд 1272 онд өөрийнх нь харьяат, нэр бүхий дөрвөн хот, тэдгээрийн эргэн тойронд мөн Анкарагийн нэг хэсэгт, Коня, Аксарай мужуудад байсан өөрийн бүх эзэмшил, эд хөрөнгөө үр ач нартаа улмаар Кыршехир, Искилиб, Талымэгини, Султанъйуги, Кайсэри зэрэг хотуудад орших исламын шашны сургууль, сүм, мөргөлийн газар болон бусад албан байгууллагад сан болгон гэрээслэн бичиж үлдээсэн байна.

Тэрбээр санд хамаарах тариалан, жимсний цэцэрлэг, тээрэм, усалгааны суваг, шашны сургууль, сүм, мөргөлийн газар, төрөл бүрийн үйлчилгээний муклагууд, халуун усны газрууд зэргийн хил хязгаарыг тодорхой заасны зэрэгцээ сангийн удирдан зохицуулахтай холбоотой асуудлаархи санал, цалин хөлс, захиран зарцуулах арга зарчмаа албан баримт болгон араб хэлээр бичүүлсэн ажээ. Уг сангийн гэрээг үйлдэхэд оролцон сангийн хөрөнгийг үнэнч шударгаар зөв зүйлд зарцуулахаа амлан гэрч болсон хүмүүсийн нэрийг араб, монгол хоёр хэлээр бичүүлэн үлдээжээ.

*МУИС-ийн ГХСС-ийн Түрэг судлалын тэнхим, докторант

Нур ад-Диний сангийн гэрээ бичгийн гурван хувилбар эх олджээ. Туркийн Кыршехир хотоос олдсон хоёр гар бичмэл нь араб, монгол хоёр хэлээр, харин Искилипийн гар бичмэл араб хэлээр бичигдсэн байна.

Кыршехирийн I гар бичмэлийг анх Түркийн судлаач Ж.Тарым 1938 онд нийтэлсэн бөгөөд «...*Caca beyin son mütevellilerinden, Recep oğullarından Ahmet oğlu uzunluğunda, 28 santimetre eninde beze yapışılı kâğıt üzerine yazılıdır. Başından epeyce bir kısmının koptuğu anlaşıyor, yazıların çoğu uçtuğu ve noktasız olduğu için okunamıyor. Sonunda küfi hatla 67 satır, ayrıca bir çok şahit adları var ...*» гэсэн бөгөөд энэ нь “Чача ноёны удмын Ахмэтийн хүү Али-ийн хадгалан буй сангийн гэрээ бичиг нь 12 м урт, 28 см өргөн даавуунаа бичигдсэн ба эхний нилээд хэсэг нь урагдсанаас гадна бичээсийн ихэнх нь бүдгэрсэн, цэгийг тэмдэглээгүй зэргээс унших боломжгүй байна” гээд төгсгөлд нь бичсэн монгол эхийг “кюфи-ээр бичсэн хэдэн хүний нэр” гэж үзсэн байна.

Кыршехирээс Ж.Тарымын илгээсэн “уйгур” үсгээр бичсэн нэгэн дурсгалын хуулбарыг музейн ерөнхий захирал Хамит Кошай 1948 оны зун монголч эрдэмтэн доктор профессор Ахмэт Тэмирт үзүүлэн ямар хэлээр бичсэн болохыг асуужээ. Тэрээр тухайн дурсгал монгол хэлээр буй бөгөөд маш чухал болохыг нь мэдэгджээ. А.Тэмир гэрээний нэг эх нь монгол хэлээр байсныг олж мэдсэн ба улмаар нарийвчлан судалж араб гурван эх тус бүрийнх нь сийрүүлэг, орчуулга, мөн монгол эхүүдийн галиг, түрк орчуулга, хэлний тайлбар, түүхийн шинжилгээ, үгийн хэлхээ зэргийг хийн “Кыршехирийн захирагч Жажагийн хүү Нур эл-Диний 1272 оны араб, монгол хэлээрх сангийн бичиг” нэртэй номоо анх 1959 онд хэвлүүлжээ.

Нур ад-Диний сангийн гэрээ бичгийн араб эхийг монгол хэлнээ буулгахад дараах хэдэн зүйл ажиглагдлаа.

Монголд өнөөгийн байдлаар араб хэлээр буй сурвалжийг араб хэлнээс монгол хэл рүү шууд орчуулсан зүйл, ялангуяа түүхэн сурвалжаас орчуулсан туршлага хараахан үгүй байгаагийн улмаас урьд өмнөх сайн орчуулгаас үлгэр авах, харьцуулан сайжруулах боломжгүй байлаа.

Араб хэлээрх түүхэн сурвалжийн эхийн нэг онцлог бол тодорхой оноосон (алдартай, ариун газар ус, хот, хүн гэх зэргийн) нэрийн ард буюу өмнө магтаал үг бичдэг. Энэ нь исламын шашинтай холбоотой юм. Гэтэл монгол уламжлалт бичгийн хэлэнд үүнтэй дүйх ёс үгүй. Тухайлбал: *الله اجمل ال قر شهرى ي و سف حاجب* - Хажиб *الله ادام و الله وق* - *فه المذكور واقفال*, Юсуф Кыршехри “**түүнийг тэнгэр ивээх болтугай**”, *الله ادام و الله وق* - нэр нь дурдагдан буй сан **тэнгэр түүнийг үргэлж арвин байлгах болтугай** ... гэх мэтээр нилээд хэдэн удаа тохиолдож байна. Үүнээс гадна Рашид ад-Диний Судрын Чуулганд «... Энэ хэрэг хэр хэмжээ алдаад ирэх дор буянтай ноён Сахиб диван Шамс-ад-дин “**түүнийг бурхан аврах болтугай.**” ..., ... Бурханы элчийн (түүний төлөө залбирч энх амгалан байлгах болтугай) гайхамшиг нь дур булаамаар бөгөөд ур дүйтэй болон түүний чин үнэн болох нь он цагийн хугацаанд илэрхий бөгөөд лавтай болсон ажгуу. ... » гэх зэргээр мөн тохиолдож байна.


Монгол хэлээр араб үгийг галиглан буулгах тогтолцоо хараахан бүрдээгүй байгаа тул одооноос зарим түгээмэл тохиолдох хэлбэрийг зөв бичиж хэвших хэрэгтэй байна. Тухайлбал: Нур ал-Дин, Нур ад-Дин, Нур эл-Дин, Рашид ад-Дин, Рашид уд-Дин, Рашид ал-Дин, Рашид эд-Дин, Рашид эд-дин, Рашид-ад-дин, Рашид-ад-Дин гэх мэт олон янзаар тэмдэглэгдсэн байдаг. *الدين نور* хэмээх үгийг үсэгчилэн буулгавал “Нур ал-дин” болох бөгөөд “дин”-ий урд тэмдэглэгдсэн “ал” нь араб хэлний нэр үгэнд холбон бичдэг тухайлах ялгац гишүүн болно. Энэхүү тухайлах ялгац гишүүнийг ямар үсгээр эхэлсэн үгэнд залгаж буйгаас нь шалтгаалан хоёр янзаар уншина. Араб хэлний цагаан толгой нь 28 гийгүүлэгч авианаас бүтэх бөгөөд эдгээрийг 14, 14-өөр нь “нарны”, “сарны” хэмээн хоёр ангилна. Тухайлах ялгац гишүүн “ал”-ийг “нарны” үсгээр эхэлсэн үгэнд залгасан тохиолдолд “ал”-ийн “л”-ийг дуудахгүй (уншихгүй), харин тухайн үгийн эхний гийгүүлэгчийг уртаар буюу дараалан орсон байдлаар дуудна. “Дин”-ий “д” нь нарны үсэг тул “ал-дин” хэмээн унших бус “ад-дин” хэмээх нь зүйтэй болж байна. Энэ нь араб хэлний *ال فصحى العربى* буюу араб бичгийн хэлний дүрэм болно.

Уг сурвалжид газар усны нэр, хүний нэр олонтаа тохиолдож байгаа нь тухайн газар нутгийн нэрийг нарийн сайн мэдэхгүй хүн уншихад төвөгтэй байна. Учир нь араб хэлэнд эгшиг үсгийг толь бичиг, сурах бичгээс бусад зүйлд тэмдэглэдэггүй. Тухайлбал: *الخرقة المزرعة* – [ал-мазра’ ат ал-хирка] ал-мазра’ ат буюу тариалангийн талбай гэх үгийг тодотгож буй оноосон нэрийн эгшигийг тэмдэглээгүйн улмаас *Хирка, Харка, Хурка, Харика, Хурака...* гэх мэтээр, эгшгээр амилуулахдаа олон хэлбэрт оруулан унших боломж байна. Хэдий тийм боловч энэхүү нэр нь Кайсэри нэрт хотын ойролцоох Хирка хэмээх тосгоны нэр мөн болохыг хам сэдэвтэй нь уялдуулан төвөггүй мэдэж болох юм. Иймээс энэ мэт араб хэлээр тэмдэглэгдсэн түүхэн сурвалж дахь оноосон нэрийг уншиж орчуулахдаа тухайн газар усны нэр, хүний нэртэй холбоотой, эрт эдүгээгийн материалыг харьцуулан үзэж судлах зайлшгүй шаардлагатай байдаг.


Исламын шашны холбогдолтой нэр томъёо олон байна. Нэг шашны холбоотой нэр томъёог нөгөө шашны нэр томъёогоор дүйлгэх буюу орлуулан орчуулахад тэр бүр оновчтой болдоггүй, эргэлзээтэй зүйл ажиглагддаг. Тухайлбал: Манай орчуулгын зохиолуудад *الله* - Аллах хэмээх үгийг Аллах Бурхан, Аллах Эзэн гэх зэргээр орчуулсан нь бий. Энэ *الله* хэмээх үгийг бид энэ удаад Тэнгэр хэмээх үгээр дүйлгэн орчуулав. Учир нь, Ил хаант улсын баруун хязгаарыг төвшитгөн тогтоосон монгол язгууртан, цэргийн эрхтнүүд тухайн үеийн түүхийн нөхцөл байдлаас үүдэж тэр газар нутагт суурьшаад асар удалгүй исламын шашинд орсон. Тэдний хэл аялгууны онцлогийг хадгалан үлдсэн араб үсгээрх толь бичгүүдэд “Аллах” гэх үгийг “Тэнгэр” хэмээн буулгасан байдгийг баримталсан болно.

Ашигласан эх хэрэглэгдэхүүн

1. Арьяажав Б. Нур ад-Диний сангийн 1272 оны гэрээ бичиг (Кыршехирийн нэгдүгээр гар бичмэлийн араб, монгол эх бичвэрийн судалгаа). /Магистрын дипломын ажил/. УБ., 2010
2. Ууганбаяр М. Кыршехирийн ноён Жажагийн хөвгүүн Нур ад-Диний бичгийн тухайд. //МСЭШБ. Боть XX (194). УБ., 2003, 244-265
3. Arıkan N., Tuğutlu E., Eraslan Y. Kırşehir Emiri Cacabey ve Medresesi “Simetrik Yaklaşımlar”. Kırşehir, 2009
4. İnalçık H. Osmanlı tarihine toplu bir bakış. //Osmanlı I. Siyaset. Ankara, 1999
5. Ligeti L. Monuments préclassiques. 1 (XIIIe et XIVe siècles). //MLMC II. Budapest, 1972
6. Şimşek A. Cacabey ve Medresesi. Kırşehir, 2006
7. Temir A. Kırşehir Emiri Caca oğlu Nur el-Din'in 1272 tarihli arapça-moğolca vakfiyesi. Ankara, 1989
8. Tumurtogoo D. Mongolian Monuments in Uighur-Mongolian Script (XIII-XVI Centuries). Taipei, 2006



Кыршехирийн I гар бичмэлийн араб эх



Кыршехирийн I гар бичмэлийн монгол эх